



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/19

Сүхбаатар сум

Жүдо бөхийн насанд хүрэгчдийн
2019 оны Монгол улсын аварга шалгаруулах тэмцээн
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.5 "а", Биеийн тамир спортын тухай хуулийн 8.1.1, 8.1.2, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жүдо бөхийн насанд хүрэгчдийн 2019 оны Монгол Улсын аварга шалгаруулах тэмцээнийг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд 2019 оны 01 дүгээр сарын 06-наас 01 дүгээр сарын 09-ний хооронд зохион байгуулсугай.

2. Тэмцээний зардалд 11.040.000 /арван нэгэн сая дөчин мянган/ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

3. Дэмжлэгт зарцуулагдах зардлыг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Мөнхбаяр/-т зөвшөөрсүгэй.

4. Тэмцээнийг тогтоосон хугацаанд удирдамж, төлөвлөгөөний дагуу чанарын өндөр түвшинд зохион байгуулан, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг 2019 оны 02 дугаар сарын 11-ний дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг Биеийн тамир, спортын газрын дарга /У.Батмөнх/-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2019 оны 01 дүгээр сарын 24 ны өдрийн
АКЗ тоот захирамжийн 01 хавсралт

Жудо бөхийн насанд хүрэгчдийн 2019 онь Монгол улсын аврага шалгаруулах тэмцээнийг
зохион байгуулах төсөв



№	Нэр төрөл	Тоо ширхэг	1 бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Хулдаасан хэвлэл	16	150,000	2,400,000
2	Шүүгчдийн цалин	20	192,000	3,840,000
3	Өндөрлөгөө тавцанг зөөх зардал	1	1,500,000	1,500,000
4	Дэвжээ хивс зөөх зардал	1	1,200,000	1,200,000
5	Лед гэрэл, хөгжим аппаратур	1	2,100,000	2,100,000
Нийт дүн				11,040,000

Төсөв зохиосон:

/А. Энх-Амгалан/

Төсөв хянасан:

/О. Мөнхбаяр/